

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/203/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн Захирал: О.Бурмаа Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт.....	18
5.1 Албан шаардлага.....	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.ГАНЧИМЭГ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/203/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 4,566.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасантай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэг нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 89,2 хувьтай тайлагнагдсан байна.

Хоолны зардал 1,022.9 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн зардал 52,145.9 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардал 7,689.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэг нь нь сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 5 дугаар түвшинд үнэлэгдсэн байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар тус бодлогын баримт бичигт нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тус цэцэрлэг нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	53,578,892.93	116,046,800.92
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,133,577.10	60,863,903.21
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,133,577.10	60,863,903.21
3121	Төгрөг	10,133,577.10	60,863,903.21
31211	Төрийн сангийн харилцах	10,133,577.10	60,863,903.21
33	АВЛАГА		5,127,332.68
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	5,127,332.68
35	БАРАА МАТЕРИАЛ	43,445,315.83	50,055,565.03
351	Түүхий эд материал	-	4,400,750.00
35110	Тусгай зориулалттай материал	-	4,376,000.00
35130	Эм боох материал	-	24,750.00
354	Хангамжийн материал	43,445,315.83	45,654,815.03
35420	Аж ахуйн материал	24,355,976.05	24,875,976.05
35460	Хүнсний материал	874,600.00	945,099.20
35470	Бусад хангамжийн материал	18,214,739.78	19,833,739.78
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	464,775,911.66	429,011,320.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	464,775,911.66	429,011,320.74
392	Биет хөрөнгө	401,048,411.81	367,453,987.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	329,964,934.99	329,964,934.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,367,452.79)	(44,688,040.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69,802,877.40	73,362,877.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,923,011.34)	(41,295,653.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,535,865.88	20,135,865.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,156,327.21)	(11,273,297.13)
39209	Зам, гүүрийн байгууламж	2,092,456.80	2,092,456.80
39210	Хуримтлагдсан элэгдэл	(492,342.72)	(615,428.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	68,797,896.45	68,797,896.45
39215	Хуримтлагдсан элэгдэл	(19,377,452.31)	(30,198,590.71)
39217	Ном	1,170,966.66	1,170,966.66
393	Биет бус хөрөнгө	63,727,499.85	61,557,333.32
39301	Програм хангамж	800,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(752,500.15)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	63,680,000.00	64,480,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,922,666.68)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	518,354,804.59	545,058,121.66
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	213,103.08	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	213,103.08	-
413	Өглөг	213,103.08	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	213,103.08	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	518,141,701.51	545,058,121.66
51	Засгийн газрын хувь оролцоо	518,141,701.51	545,058,121.66
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	486,916,191.33	486,916,191.33
51101	Өмч:- төрийн	486,916,191.33	486,916,191.33
512	Хуримтлагдсан үр дүн	(7,159,345.07)	19,757,075.08
51210	Өмнөх үеийн үр дүн	(526,050,503.25)	(7,159,345.07)
51220	Тайлант үеийн үр дүн	518,891,158.18	26,916,420.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,384,855.25	38,384,855.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	518,354,804.59	545,058,121.66

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	975,508,898.98	551,973,860.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	533,699,098.39	6,523,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	533,699,098.39	6,523,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	533,699,098.39	6,523,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,523,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	533,699,098.39	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,809,800.59	545,450,860.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	364,327,300.00	496,526,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	364,327,300.00	496,526,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,482,500.59	48,924,060.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,482,500.59	48,924,060.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	456,617,740.80	525,057,440.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,617,740.80	525,057,440.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,617,740.80	525,057,440.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,793,823.37	351,625,559.49
210101	Үндсэн цалин	228,307,664.37	253,980,448.49
210102	Нэмэгдэл	60,026,701.00	84,700,939.00
210104	Урамшуулал	11,459,458.00	12,944,172.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,675,954.72	42,792,290.44
210201	Тэтгэврийн даатгал	24,337,806.96	29,887,575.43
210202	Тэтгэмжийн даатгал	2,863,269.75	3,526,738.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,290,615.86	2,721,354.47
210204	Ажилгүйдлийн даатгал	534,120.27	603,661.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,650,141.88	6,052,960.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,756,202.81	39,924,060.20
210301	Гэрэл, цахилгаан	6,847,715.11	8,020,770.20
210302	Түлш, халаалт	31,708,167.70	29,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,320.00	2,403,290.00
2105	Нормативт зардал	29,496,164.00	34,743,450.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	386,525.00	-
210502	Хоол, хүнс	29,109,639.00	34,743,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,970,000.00	6,470,000.00
210604	Урсгал засвар	3,970,000.00	6,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	500,000.00	617,826.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	617,826.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,425,595.90	48,884,253.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,841,714.00	6,592,363.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	553,800.00	367,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	37,030,081.90	41,924,590.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	518,891,158.18	26,916,420.15
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	518,891,158.18	26,916,420.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>441,809,800.59</u>	<u>551,973,860.20</u>	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	441,809,800.59	551,973,860.20	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	364,327,300.00	496,526,800.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	364,327,300.00	496,526,800.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	6,523,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	6,523,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,482,500.59	48,924,060.20	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,482,500.59	48,924,060.20	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>420,146,223.49</u>	<u>495,083,534.09</u>	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	420,146,223.49	495,083,534.09	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,146,223.49	495,083,534.09	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	298,259,225.80	352,711,250.41	
210101	Үндсэн цалин	225,180,664.00	250,778,252.40	
210102	Нэмэгдэл	61,907,153.80	89,068,807.01	
210104	Урамшуулал	11,171,408.00	12,864,191.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,997,449.21	47,047,035.28	
210201	Тэтгэврийн даатгал	25,159,420.76	31,111,773.73	
210202	Тэтгэмжийн даатгал	2,962,411.86	3,660,485.22	
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,369,849.66	2,928,277.15	
210204	Ажилгүйдлийн даатгал	491,452.02	635,488.22	
210205	Эрүүл мэндийн даатгал	5,014,314.91	8,711,010.96	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,719,459.48	39,924,060.20	
210301	Гэрэл, цахилгаан	7,169,529.48	8,020,770.20	
210302	Түлш, халаалт	30,290,000.00	29,500,000.00	
210303	Цэвэр, бохир ус	3,259,930.00	2,403,290.00	
2105	Нормативт зардал	29,453,039.00	34,813,949.20	
210502	Хоол, хүнс	29,453,039.00	34,813,949.20	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,970,000.00	9,000,000.00	
210604	Урсгал засвар	3,970,000.00	9,000,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	760,700.00	617,826.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	760,700.00	617,826.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,986,350.00	10,969,413.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,736,350.00	9,029,613.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,250,000.00	1,939,800.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>21,663,577.10</u>	<u>56,890,326.11</u>	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,530,000.00	6,160,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,530,000.00	6,160,000.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	11,530,000.00	6,160,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,530,000.00	6,160,000.00	

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(11,530,000.00)</u>	<u>(6,160,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	10,133,577.10	50,730,326.11
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,133,577.10
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,133,577.10	60,863,903.21

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	486,916,191.33	38,384,855.25	(526,050,503.25)	(749,456.67)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	486,916,191.33	38,384,855.25	(526,050,503.25)	(749,456.67)
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	518,891,158.18	518,891,158.18
8	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	486,916,191.33	38,384,855.25	(7,159,345.07)	518,141,701.51
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
11	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	486,916,191.33	38,384,855.25	(7,159,345.07)	518,141,701.51
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
16	Тайлант үеийн үр дүн	-	-	26,916,420.15	26,916,420.15
17	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	486,916,191.33	38,384,855.25	19,757,075.08	545,058,121.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	562,107,460.20	501,243,534.09	60,863,926.11	89.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,584,460.20	501,243,534.09	54,340,926.11	90.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,584,460.20	501,243,534.09	54,340,926.11	90.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	404,156,000.00	352,711,250.41	51,444,749.59	87.3
210101	Үндсэн цалин	263,611,100.00	250,778,252.40	12,832,847.60	95.1
210102	Нэмэгдэл	126,262,700.00	89,068,807.01	37,193,892.99	70.5
210104	Урамшуулал	14,282,200.00	12,864,191.00	1,418,009.00	90.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,345,300.00	47,047,035.28	8,298,264.72	85.0
210201	Тэтгэврийн даатгал	37,634,200.00	31,111,773.73	6,522,426.27	82.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,427,900.00	3,660,485.22	767,414.78	82.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,542,200.00	2,928,277.15	613,922.85	82.7
210204	Ажилгүйдлийн даатгал	885,600.00	635,488.22	250,111.78	71.8
210205	Эрүүл мэндийн даатгал	8,855,400.00	8,711,010.96	144,389.04	98.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,924,060.20	39,924,060.20	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	8,020,770.20	8,020,770.20	-	100.0
210302	Түлш, халаалт	29,500,000.00	29,500,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	2,403,290.00	2,403,290.00	-	100.0
2105	Нормативт зардал	35,836,900.00	34,813,949.20	1,022,950.80	97.1
210502	Хоол, хүнс	35,836,900.00	34,813,949.20	1,022,950.80	97.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00	9,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	9,000,000.00	9,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	657,400.00	617,826.00	39,574.00	94.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	657,400.00	617,826.00	39,574.00	94.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,664,800.00	17,129,413.00	(6,464,613.00)	160.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,692,700.00	15,189,613.00	(6,496,913.00)	174.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,972,100.00	1,939,800.00	32,300.00	98.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,523,000.00	-	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	6,523,000.00	-	-	-
222001	Тоног төхөөрөмж	6,523,000.00	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	562,107,460.20	551,973,860.20	10,133,600.00	98.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	496,526,800.00	496,526,800.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	496,526,800.00	496,526,800.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,924,060.20	48,924,060.20	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	48,924,060.20	48,924,060.20	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,656,600.00	6,523,000.00	10,133,600.00	39.2

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,523,000.00	6,523,000.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	10,133,600.00	-	10,133,600.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	10,133,577.10	(10,133,577.10)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	60,863,903.21	(60,863,903.21)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	100.00	100.00	-	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	100.00	100.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.00	24.00		
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	13.00	13.00	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхдийн болон багшийн бүх талын тасралтгүй хөгжлийг хангахад хамтран ажиллах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх,
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан тасралтгүй хөгжих олон хувилбарт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж менежментийг сайжруулах,
- Мэргэжлийн бүлгийн үйл ажиллагааг өргөжүүлж тэргүүлэх багшийн манлайлал, үүрэг оролцоог нэмэгдүүлэх,
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээг эв зөийг эрхэмлэж мөрдөж сахилга хариуцлагыг чандлан сахиж идэвх санаачилгатай бүтээлчээр ажиллах ,
- Хүүхэд бүрийн сурч хөгжих , төлөвшихөд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Боловсролын ерөнхий хууль 2023 оны 7 дугаар сарын 7-нд шинэчлэгдэн батлагдсан,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,*
- *БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд:*
 1. *"ЕБС-д сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх",*
 2. *"Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах" чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй

боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,703.3 мянган төгрөгөөр буюу 5,2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,133.58	60,863.90	50,730.33
Авлага	-	5,127.33	5,127.33
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	43,445.32	50,055.57	6,610.25
Үндсэн хөрөнгө	464,775.91	429,011.32	(35,764.59)

Нийт хөрөнгө	518,354.80	545,058.12	26,703.32
Өр төлбөр	213.10	-	(213.10)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	518,141.70	545,058.12	26,916.42
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	518,354.80	545,058.12	26,703.32

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 60,863.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтийг төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасангай холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 5,127.3 мянган төгрөг болж өссөн нь НДШ-ийн 1,235.2 мянган төгрөг, ХАОАТ-ын 3,859.8 мянган төгрөг, үйлдвэрчний эвлэлийн 32.3 мянган төгрөгийн авлага тус тус үүсгэсэн нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 429,011.3 мянган төгрөг болж 35,764.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 41,924.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 447,477.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 50,510.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 497,987.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 132,314.1 мянган төгрөгийг бууруулж 315,163 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 50,510.9 мянган төгрөгөөр тус тус нийт 365,673.9 мянган төгрөгийн санхүүжилтийг баталсан байна.

Төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар 2023 оны 1,6,9,11,12-р саруудад нийт 6 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвийн санхүүжилтийг 198,020.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт 513,183.4 мянган төгрөг, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 1,586.8 мянган төгрөгөөр бууруулж 48,924.0 мянган төгрөг нийт **562,107.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 513,183.4 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 48,924.0 мянган төгрөг нийт **562,107.4** мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 501,243.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 501,243.5 сая төгрөг буюу 89,2 хувьтай байгаа нь хоолны зардал 1,022.9 мянган төгрөгөөр, боловсролын стандарт,

сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийн зардал 52,145.9 мянган төгрөгөөр, сургалтын хэвийн үйл ажиллагаа хөтөлбөрийн зардал 7,689.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл
/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт хувиар
	Улсын төсвөөс санхүүжих				
1	81605 - Эрүүл мэндийг дэмжих	1,021.10	1,020.00	1.10	99.9
2	81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	35,836.86	34,813.95	1,022.91	97.1
3	81816 - Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,009.70	2,005.00	4.70	99.8
4	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,356.10	1,356.10	-	100.0
5	81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	330,655.73	278,509.85	52,145.87	84.2
6	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа	135,780.89	128,091.57	7,689.32	94.3
7	120010- Дээд шатны захирагчаас	6,523.00	6,523.00	-	100.0
	Дүн	513,183.38	452,319.47	60,863.90	88.1
1	Орон нутгийн төсвөөс санхүүжих				
2	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зард	48,924.06	48,924.06	-	100.0
	НИЙТ	562,107.44	501,243.53	60,863.90	89.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Шууд худалдан авах босго үнээс давсан /2023 оны анх батлагдсан төсвөөр/ 35,836.9 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Тодруулбал мах, хүнсний материалыг Галил этоос ХХК, Цахим ертөнц ХХК, Органик барчин ХХК, Эко наран гэрэлт ХХК, Гацал хайрхан ХХК, иргэн Мөнхцэцэг, Энхболд нартай тус тус гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан

гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-ийн аудитор Д.Даваасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал О.Бурмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Аав ээжийн тэнгэрлэг буян аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 456,617.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,566.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 27 төрлийн 170 мэдээлэл байршуулахаас 5 төрлийн мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

Хугацаа хоцроосон мэдээллүүд:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал – хэтрэлт, хэмнэлтийн тайлбар оруулаагүй.
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт
- Хагас жилийн санхүүгийн тайлан
- Дараа жилийн төсвийн төсөл
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгөгдсөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулах, зөрчлийг давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу тус цэцэрлэгийн нягтлан бодогч У.Оюунжаргалд хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан 35,836.9 мянган төгрөгийн хоол, хүнсний материалын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална”, 48 дугаар зүйлийн 48.5-т “Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ”, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 1.Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд

хязгаар: Бараа-70.0 сая төгрөг, 2. “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, батлуулж, тайлагнах, хуульд заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулсны үндсэн дээр худалдан авалтыг хийж гүйцэтгэх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус цэцэрлэгийн худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус цэцэрлэгийн 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй болон авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлагын биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	3,208.1	1	3,208.1	100
Нийт дүн	1	3,208.1	1	3,208.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “ Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Уг албан бичгийн дагуу нягтлан бодогч У.Оюунжаргалын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу 868.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8,146.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйгээс 5,095.0 мянган төгрөгийн / НДШ-ийн 1,235.2 мянган төгрөгийн, ХАОАТ-ын 3,859.8 мянган төгрөгийн/ авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. .

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог урьдчилан хянасны үндсэн дээр өр төлбөр, авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 3,019.5 мянган төгрөгийг гүйлгэн, зориулалт бусаар зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд төсвийн зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага, өр төлбөр үүсгэсэн	1	5,127.3			1	5,127.3						
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	3,019.5			1	3,019.5						
Дүн	2	8,146.8			2	8,146.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд мэдээлбэл зохих 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1						1	
Дүн	1						1	
Нийт дүн	2						1	